



# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/129/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий

Утас: 70522734

Цахим хаяг: [gan-ulziit@audit.gov.mn](mailto:gan-ulziit@audit.gov.mn)

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 70523020

Цахим хаяг: [oyuntulkhuur.u@audit.gov.mn](mailto:oyuntulkhuur.u@audit.gov.mn)

Аудитор: Б.Уранбилэг

Утас: 70523020

Цахим хаяг: [uranbileg.b@audit.gov.mn](mailto:uranbileg.b@audit.gov.mn)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

---

1.Төрийн аудитын санал, дүгнэлт .....	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан .....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан .....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .....	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан .....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан .....	10
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	11
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	11
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт .....	11
3.4. Материаллаг байдал .....	12
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд .....	12
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт .....	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	14
3.9. Аудитын илрүүлэлт.....	14
Залруулсан алдаа.....	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил .....	14
Аудитын зөвлөмж.....	15
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд .....	15
4. Менежментийн захидал .....	16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт .....	17

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

  
**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,  
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,  
Утас: (705) 2-27-34  
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,  
АУДИТЫН АЛБАНЫ ДАРГА  
Х.ОЮУНТУЯА ТАНАА

2021.02.08 № 16/36  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасны дагуу 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар 2020 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

2

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

#### Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Данс	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	4,327,967.00	13,922,485.00
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		
314	Замд яваа мөнгөн хөрөнгө		
33	АВЛАГА	943,151.00	259,910.00
331	Ажиллагчидтай холбогдсон авлага	189,000.00	189,000.00
335	Бусад авлага	754,151.00	70,910.00
3351	Байгууллагаас авах авлага	754,151.00	70,910.00
34	УРЬДЧИЛГАА		7,031,000.00
346	Урьдчилж гарсан зардал		2,950,000.00
3471	Урьдчилгаа тооцоо		4,081,000.00
34714	Томилолтын урьдчилгаа		4,081,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	3,384,816.00	6,631,575.00
354	Хангамжийн материал	3,384,816.00	6,631,575.00
3541	Бичиг хэргийн материал	739,960.00	626,300.00
3542	Аж ахуйн материал	2,609,075.00	4,511,375.00
3543	Сэлбэг хэрэгсэл	31,000.00	473,900.00
3544	Түлш, шатах тослох материал	4,781.00	1,020,000.00
36	НӨӨЦИЙН БАРАА		
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	47,235,335.27	48,700,952.38
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ		
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	47,235,335.27	48,700,952.38
392	Биет хөрөнгө	47,199,210.13	47,261,785.66
39203	Авто-тээврийн хэрэгсэл	39,900,000.00	39,900,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1,995,000.00	-9,975,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	13,477,999.00	20,655,899.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-9,646,415.70	-12,177,080.09
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,009,106.00	15,502,666.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-5,546,479.17	-6,644,699.25
393	Биет бус хөрөнгө	36,125.14	1,439,166.72
39301	Програм хангамж	289,000.00	2,016,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-252,874.86	-576,833.28
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	51,563,302.27	62,623,437.38
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР		97,600.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		97,600.00
413	Өглөг		97,600.00
4136	Бусад өглөг		97,600.00
41361	Байгууллагад төлөх өглөг		97,600.00
414	Урьдчилж орсон орлого		
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		
422	Урт хугацаат зээл		
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	51,563,302.27	62,525,837.38
51	Засгийн газрын хувь оролцоо	51,563,302.27	62,525,837.38
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан		
51101	Өмч: - төрийн		
512	Хуримтлагдсан үр дүн	51,563,302.27	62,525,837.38
5121	Өмнөх үеийн үр дүн	51,563,302.27	51,563,302.27
5122	Тайлант үеийн үр дүн		10,962,535.11
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	51,563,302.27	62,623,437.38

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/**

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	204,077,900.00	200,312,567.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,156,000.00	1,777,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	40,156,000.00	1,777,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,156,000.00	
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	40,156,000.00	
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө		1,777,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	163,921,900.00	198,535,567.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		301,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		301,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,921,900.00	198,234,067.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,921,900.00	198,234,067.17
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	162,766,480.30	189,350,032.06
21	УРСГАЛ ЗАРДАЛ	162,766,480.30	189,350,032.06
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,818,875.67	187,051,566.06
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,539,410.00	127,420,927.45
210101	Үндсэн цалин	103,374,410.00	120,452,178.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,165,000.00	6,968,749.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,330,447.00	15,689,152.54
210201	Тэтгэврийн даатгал	9,384,207.00	10,859,114.85
210202	Тэтгэмжийн даатгал	971,829.00	1,272,848.65
210203	ҮОМШӨ-ний даатгал	773,719.00	1,014,918.92
210204	Ажилгүйдлийн даатгал	206,624.00	231,115.46
210205	Эрүүл мэндийн даатгал	1,994,068.00	2,311,154.66
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,080,544.37	6,038,775.77
210301	Гэрэл, цахилгаан	855,819.37	1,456,380.57
210302	Түлш, халаалт	3,849,629.00	3,853,589.00
210303	Цэвэр, бохир ус	375,096.00	728,806.20
2104	Хангамж, бараа материалын зардал	8,083,689.80	9,406,578.41
210401	Бичиг хэрэг	1,782,318.80	1,315,960.00
210402	Тээвэр, шатахуун	5,125,619.00	6,870,197.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,175,752.00	1,048,421.41
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		172,000.00
2105	Нормативт зардал		419,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		419,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	40,000.00	3,640,040.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		240,040.00
210604	Урсгал засвар	40,000.00	3,400,000.00
2107	Томиллолт, зочны зардал	13,740,000.00	10,999,000.00
210702	Дотоод албан томиллолт	13,740,000.00	10,999,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,809,770.00	1,005,249.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,859,760.00	210,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	216,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	734,010.00	717,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		50,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		27,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,195,014.50	12,432,842.89
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	180,000.00	500,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,015,014.50	11,932,842.89
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,947,604.63	2,298,466.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,998,501.00	2,298,466.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,998,501.00	2,298,466.00
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	949,103.63	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	949,103.63	
	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		
	Дотоод эх үүсвэрээр		

**Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	41,311,419.70	10,962,535.11
145	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН		
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	41,311,419.70	10,962,535.11

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/**

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	163,921,900.00	198,535,567.17
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО		
120	Нийтлэг татварын бус орлого		
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого		
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	163,921,900.00	198,535,567.17
1310	Улсын төвлөрсөн төсвөөс		
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		301,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		301,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,921,900.00	198,234,067.17
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,921,900.00	198,234,067.17
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	158,838,900.00	186,914,107.17
21	УРСГАЛ ЗАРДАЛ	158,838,900.00	186,914,107.17
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	153,891,295.37	184,615,607.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	110,080,999.00	127,558,752.05
210101	Үндсэн цалин	102,915,999.00	119,054,752.05
210103	Унаа хоолны хөнгөлөлт	7,165,000.00	8,504,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,450,899.00	15,564,440.94
210201	Тэтгэврийн даатгал	9,167,476.00	10,762,146.02
210202	Тэтгэмжийн даатгал	1,082,675.00	1,266,134.59
210203	ҮОМШӨ-ний даатгал	866,000.00	1,009,547.07
210204	Ажилгүйдлийн даатгал	212,377.00	228,932.77
210205	Эрүүл мэндийн даатгал	2,122,371.00	2,297,680.49
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,720,375.37	5,460,820.77
210301	Гэрэл, цахилгаан	855,819.37	1,456,380.57
210302	Түлш, халаалт	4,399,576.00	3,303,642.00
210303	Цэвэр, бохир ус	464,980.00	700,798.20
2104	Хангамж, бараа материалын зардал	7,977,012.00	11,041,337.41
210401	Бичиг хэрэг	1,494,700.00	2,107,500.00
210402	Тээвэр, шатахуун	5,130,400.00	7,885,416.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,351,912.00	1,048,421.41
2105	Нормативт зардал		591,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		591,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		4,982,440.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		1,328,440.00
210604	Урсгал засвар		3,654,000.00
2107	Томилолт, зочны зардал	13,740,000.00	14,961,567.00
210702	Дотоод албан томилолт	13,740,000.00	14,961,567.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,046,010.00	1,005,249.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,162,000.00	210,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	150,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	734,010.00	717,675.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар		50,574.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо		27,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	876,000.00	3,450,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	876,000.00	3,450,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,947,604.63	2,298,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,998,501.00	2,298,466.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,998,501.00	2,298,466.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт		34
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		34

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	949,103.63	
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	949,103.63	
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	5,083,000.00	11,621,460.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)		
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		11,621,460.00
22	Биет ба биет бус хөрөнгө худалдан авах		11,621,460.00
	Дотоод эх үүсвэрээр		11,621,460.00
222001	Тоног төхөөрөмж		7,177,900.00
223001	Бусад хөрөнгө		4,443,560.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		-11,621,460.00
145	Бусад эх үүсвэр		
25	Санхүүгийн үйл ажиллагааны зардал		
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	5,083,000.00	
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	<b>2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	10,251,882.57	10,251,882.57
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>10,251,882.57</b>	10,251,882.57
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	43,702,804.70	43,702,804.70
C08	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>53,954,687.27</b>	53,954,687.27
D01	<b>2017 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>53,954,687.27</b>	53,954,687.27
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	-	-	<b>53,954,687.27</b>	53,954,687.27
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	10,962,535.11	10,962,535.11
D09	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	-	-	<b>64,917,222.38</b>	64,917,222.38

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	202,341,200.00	198,234,067.17	4,107,132.83	98%
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	202,341,200.00	186,612,607.17	15,728,592.83	92%
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	200,341,200.00	184,615,607.17	15,725,592.83	92%
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	127,892,800.00	127,558,752.05	334,047.95	100%
210101	Үндсэн цалин	119,388,800.00	119,054,752.05	334,047.95	100%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	8,504,000.00	8,504,000.00	-	100%
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,986,600.00	15,564,440.94	422,159.06	97%
210201	Тэтгэврийн даатгал	10,870,900.00	10,762,146.02	108,753.98	99%
210202	Тэтгэмжийн даатгал	1,278,900.00	1,266,134.59	12,765.41	99%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,023,100.00	1,009,547.07	13,552.93	99%
210204	Ажилгүйдлийн даатгал	255,800.00	228,932.77	26,867.23	89%
210205	Эрүүл мэндийн даатгал	2,557,900.00	2,297,680.49	260,219.51	90%
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	7,957,500.00	5,460,820.77	2,496,679.23	69%
210301	Гэрэл, цахилгаан	1,035,400.00	1,456,380.57	(420,980.57)	141%
210302	Түлш, халаалт	4,942,100.00	3,303,642.00	1,638,458.00	67%
210303	Цэвэр, бохир ус	1,980,000.00	700,798.20	1,279,201.80	35%
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	11,513,300.00	11,041,337.41	471,962.59	96%
210401	Бичиг хэрэг	2,107,500.00	2,107,500.00	-	100%
210402	Тээвэр, шатахуун	7,894,400.00	7,885,416.00	8,984.00	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,511,400.00	1,048,421.41	462,978.59	69%
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	600,000.00	591,000.00	9,000.00	99%
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	600,000.00	591,000.00	9,000.00	99%
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	15,054,000.00	4,982,440.00	10,071,560.00	33%
210601	Багаж, техник, хэрэгсэл	11,400,000.00	1,328,440.00	10,071,560.00	12%
210604	Урсгал засвар	3,654,000.00	3,654,000.00	-	100%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	15,000,000.00	14,961,567.00	38,433.00	100%
210702	Дотоод албан томилолт	15,000,000.00	14,961,567.00	38,433.00	100%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,337,000.00	1,005,249.00	331,751.00	75%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	210,000.00	210,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	795,000.00	717,675.00	77,325.00	90%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	155,000.00	50,574.00	104,426.00	33%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	27,000.00	27,000.00	-	100%
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	5,000,000.00	3,450,000.00	1,550,000.00	69%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	3,450,000.00	1,550,000.00	69%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	2,000,000.00	1,997,000.00	3,000.00	100%
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	2,000,000.00	1,997,000.00	3,000.00	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,000,000.00	1,997,000.00	3,000.00	100%
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	-	<b>11,621,460.00</b>		
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	-	11,621,460.00		
222001	Тоног төхөөрөмж	-	6,759,900.00		
223001	Бусад хөрөнгө	-	4,861,560.00		
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	202,341,200.00	198,234,067.17	4,107,132.83	98%
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	202,341,200.00	198,234,067.17	4,107,132.83	98%
132001	Орон нутгийн төсвөөс	202,341,200.00	198,234,067.17	4,107,132.83	98%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	8.00	8.00	-	100%
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	-	100%
620002	Гүйцэтгэх ажилтан	7.00	7.00	-	100%

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	-	<b>301,466.00</b>	<b>(301,466.00)</b>	
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	-	<b>301,466.00</b>	<b>(301,466.00)</b>	
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	-	<b>301,466.00</b>	<b>(301,466.00)</b>	
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	-	<b>301,466.00</b>	<b>(301,466.00)</b>	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	301,466.00	(301,466.00)	
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	-	<b>301,500.00</b>	<b>(301,500.00)</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	-	<b>301,500.00</b>	<b>(301,500.00)</b>	
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	301,500.00	(301,500.00)	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1. Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг дарга Х.Оюунтуяа танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 13-аас 2021 оны 01 дүгээр сарын 15-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Б.Уранбилэг хариуцаж хэрэгжүүлэв.

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 13-ны өдрийн 20 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй**

Албаны үйл ажиллагааны үндсэн зорилго нь хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хянах, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр арга хэмжээ, хөрөнгө оруулалт зэрэгт санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитыг хийх, үнэлэлт өгөх, дүгнэлт, зөвлөмж гаргах, төсөв захирагчдыг эрсдэлийн удирдлагаар хангах, тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх, удирдлагыг холбогдох мэдээллээр хангахад оршино.

##### **Үйл ажиллагааны үндсэн чиглэл**

##### **1. Санхүүгийн хяналт шалгалтын чиглэлээр**

Улсын болон орон нутгийн төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд санхүүгийн хяналт шалгалтыг хэрэгжүүлнэ. Уг хяналт шалгалтыг байгууллагын хүсэлт, дээд газрын байгууллагын шийдвэрээр хийж болно.

##### **2. Дотоод аудитын чиглэлээр**

Дотоод аудитын үйл ажиллагаа нь гол төлөв байгууллагын дотоод хяналтыг сайжруулахад чиглэгддэг. Дотоод хяналтын үйл явц үр нөлөө, үр ашигтай байдлыг үнэлэн, байнгын сайжруулалтыг санал болгох замаар удирдлагад туслалцаа үзүүлэх үүрэгтэй.

#### **3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт**

Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 оны санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус албаны санхүүгийн үйл ажиллагаанд 2020 онд дотоод хяналт хийгдээгүй байна.

### 3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, эрсдэлийн түвшнийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшнийг 2020 оны 3-р улирлын тайлангийн цэвэр хөрөнгийн 723,690.4 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 723.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

### 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 11,060.14 мянган төгрөгөөр буюу 21.4 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1.00	2.00	3=2-1
Мөнгөн хөрөнгө			-
Авлага	943.1	259.9	(683.2)
Урьдчилгаа	-	7,031.0	7,031.0
Бараа материал	3,384.8	6,631.5	3,246.7
Үндсэн хөрөнгө	47,235.3	48,700.9	1,465.6
<b>Нийт хөрөнгө</b>	<b>51,563.3</b>	<b>62,525.8</b>	<b>10,962.5</b>
Өр төлбөр	-	97.6	97.6
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	51,563.3	62,525.8	10,962.5
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>51,563.3</b>	<b>62,525.8</b>	<b>10,962.5</b>

Авлага дансны үлдэгдэл мянган төгрөг болж 259.9 мянган төгрөгөөр буурсан нь байна. Авлага дансны үлдэгдэлд 2017 онуудад үүссэн 189.0 мянган төгрөгийн НДШ-ийн авлага, 21.0 мянган төгрөгийн татварын авлага, 2020 онд үүссэн 49.9 мянган төгрөгийн Чандмань Илч ОНӨХХК-д илүү шилжүүлсэн цэвэр, бохир усны төлбөрийн авлага, нэмэлт санхүүжилтийн данснаас буцаан төвлөрүүлсэн 34 төгрөгийг шилжүүлснээр үүссэн авлага байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 7,031.0 мянган төгрөг болж 7,031.0 мянган төгрөгөөр өссөн нь 2020 онд албан томилолтоор ажиллахаар төлөвлөн олгож ажиллаж байх хугацаанд цар тахалтай холбоотойгоор ажлаа бүрэн дуусгаагүйгээс шалтгаалжээ. 2021 оны томилолтыг үргэлжлүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн тул урьдчилгаа дансанд бүртгэж тайлагнасан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 6.631.5 мянган төгрөг болж 3,246.7 мянган төгрөгөөр өссөн цар тахалтай холбоотойгоор тээвэр шатахууны зардалд үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 48,700.9 мянган төгрөг болж 1,465.6 мянган төгрөгөөр өссөн нь шинээр хөрөнгө худалдан авалт хийснээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 11,621.5 мянган төгрөгийн худалдан авалт хийж, хөрөнгийн зардлаар бүртгэж тайлагнасан байна.

Үндсэн хөрөнгө үнэ төлбөргүй 1,777.0 мянган төгрөгийн программ хангамж шилжүүлж авсан, шилжүүлсэн болон акталсан хөрөнгө байхгүй байна.

Биет бус хөрөнгө /программ хангамж/ 1,777,0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь НББ-ийн программ, эд хариуцагчийн программыг шинээр ашиглаж эхэлснээр бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл мянган төгрөг болж 97.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд бичиг хэргийн зардал хүрэлцээгүйгээс байгууллагад төлөх өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Санхүүгийн хяналт, аудитын албаны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 8,223.7 мянган төгрөгөөр буюу 4.1 хувиар буурсан байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлого, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого өндөр дүнтэй байснаас тайлант оны нийт орлогын дүн буурсан үзүүлэлттэй байна.

Нийт зардал өмнөх оноос 26,293.6 мянган төгрөгөөр буюу 13.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин хөлс ба нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлууд байна. Мөн өмнөх оноос хичээл, үйлдвэрлэлийн дадлагын зардал нэмэгдсэн байна. Энэ нь 2020 оны 1 дүгээр улиралд Сангийн яамны Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагын газрын удирдах ажилтны зөвлөгөөн Сайншанд суманд зохион байгуулагдахаар төлөвлөгдөж байсантай холбоотойгоор төсөв нэмж батлагдсанаас шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 62,525.8 мянган төгрөг болж 10,962.5 мянган төгрөгөөр өссөн нь давагдашгүй хүчин зүйлийн улмаас буюу цар тахлын улмаас 2,950.0 мянган төгрөгийн урьдчилж гарсан зардал, 4,081.0 мянган төгрөгийн томилолтын урьдчилгааг олгосноор, эргэлтийн бус хөрөнгө 1,465.6 мянган төгрөгөөр өссөн, эргэлтийн хөрөнгө 9,594.5 мянган төгрөгөөр өссөн, авлага 683.2 мянган төгрөгөөр буурсан, өр төлбөр 97.6 мянган төгрөгөөр өссөн зэргээс шалтгаалжээ.

### **3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 217,483.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 217,483.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 15,142.8 мянган төгрөгөөр бууруулж 202,341.2 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь цар тахалтай холбоотойгоор зарим зардал хэмнэхтэй холбоотой байна.

#### **Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 202,341.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 202,341.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 198,234.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 198,234.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл мянган 198,234.1 төгрөг буюу 98 хувьтай байгаа нь орон нутгаас 4,107.1 мянган төгрөгийн санхүүжилт дутуу олгосонтой холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### **Нэмэлт санхүүжилт**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн орлогоор бусад байгууллагаас 301.5 мянган төгрөгийн шагналыг шилжүүлж, нэг удаагийн тэтгэмж, урамшууллын зардалд 301.5 зарцуулж, 34 төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### **3.7. Шилэн дансны мэдээлэл**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 43 мэдээллээс хугацаандаа оруулсан 41 мэдээлэл, хугацаа хоцроосон 2 мэдээлэл байна.

### **3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнөх онд аудитад хамрагдаагүй буюу итгэл үзүүлсэн байна.

### **3.9. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 26,963.7 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 24,286.7 мянган төгрөгийн алдааг залруулж, 2,677.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх тухай 1 зөвлөмж хүргүүлээ.

#### **Залруулсан алдаа**

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

- Ерөнхий журналыг шалгахад өмнөх оны авлага болох 105.3 мянган төгрөгийг тайлант оны зардлаар бүртгэж тайлагнасныг залруулав.
- Цалингийн бүртгэлийг шалгахад урьдчилгаа цалин болох 23,891.6 мянган төгрөгийг өглөгөөр бүртгэж, тайлагнасныг залруулав.
- Үнэ төлбөргүй хүлээн авсан программ хангамжийг бүртгэлд тусгахдаа ашиглах хугацаа оруулаагүйгээс 287.8 мянган төгрөгийн хасагдуулага тооцоогүйг залруулав.

Аудитаар 2,677.0 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж хүргүүлээ. Үүнд:

1. Тайлант онд багаж хэрэгслийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2,677.0 мянган төгрөгийн үнэ бүхий гэр худалдан авсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн

сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-ыг тус тус зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж хүргүүлэх.

### **Аудитын зөвлөмж**

Аудитаар илэрсэн 2,677.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 1 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

### **3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД**

Анхаарал татахуйц асуудалд байхгүй байна.

#### 4. Менежментийн захидал

---

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Зардлыг данстай холбоотой асуудал*

- 1.1. Илрүүлэлт: Тайлант онд багаж хэрэгслийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2,677.0 мянган төгрөгийн үнэ бүхий гэр худалдан авсан байна.
- 1.2. Эрсдэл: Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулах.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Эдийн засгийн ангилал”-д заасны дагуу батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Байхгүй

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021/01/15	Аудитын нэр: Санхүүгийн хяналт, аудитын албаны 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2021/129/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Санхүүгийн хяналт, аудитын алба	Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Тайлант онд багаж хэрэгслийн зардлаас эдийн засгийн ангилал зөрчиж 2,677.0 мянган төгрөгийн үнэ бүхий гэр худалдан авсан байна.	2,677.0	Зөвлөмж хүргүүлэх	Дарга, нягтлан бодогч	Х.Оюунтуяа, Б.Лхагвасүрэн
	<b>ДҮН</b>	<b>2,677.0</b>			